

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**1 дүгээр хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм №1  
2018.01.16**

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны, Увс нуурын ай савын Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга (ахлах түшмэл ТЗ-8)-ын болон Цаг уур, орчны шинжилгээний газрын Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсийн, Урьдчилан мэдээлэх хэлтсийн дарга (ахлах түшмэл ТЗ-9)-ын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулсан дүн, тухайн ажлын байрны албан тушаалд дүгнэлт гаргуулах, нэр дэвшүүлэх тухай	1.Даваасүрэнгийн Болорчулууныг Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны даргын, Бороодойн Одсүрэнг Увс нуурын ай савын Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад, Ламжавын Оюунжаргалыг Цаг уур, орчны шинжилгээний газрын Урьдчилан мэдээлэх хэлтсийн даргын, Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд нэр дэвшүүлж, дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн Чунагийн Пунцагдорж, Дашзэвгийн Уламбаяр нарын оноо тэнцсэн тул уг албан тушаалд хуулийн хүрээнд томилох эрхийг төсвийн төвлөрүүлэн захирагч, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшинд тус тус санал болгож тогтоол гаргахаар тогтов.
2	Бусад асуудал /Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1340 дугаар албан бичгээр ирүүлсэн "Тайлан, судалгаа ирүүлэх тухай" /	1.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 2 дугаар хуралдаанаар хэлэлцэж 03 дугаар тогтоолоор баталсан Салбар зөвлөлийн гишүүдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар хийсэн ажлын 2017 оны тайлан бичиж салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад 2018 оны 1 дүгээр сарын 20-ны дотор багтаан өгөхийг гишүүд Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Х.Батжаргал Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга Г.Нямдаваа, Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мягмар Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга Ч.Батсансар, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшинг нэрт даалгасугай.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дугаар хуралдаан 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 16 цаг 30 минутаас 301 тоот өрөөнд болно.

Салбар зөвлөлийн хуралдаан №1 (2018.01.16)